

## 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

ЧЦД -ийн уурхай 2023 онд уулын ажлын төлөвлөгөөгөөр хүдрийн 2, 3, 5-р биетүүдийн 0.6 га талбайд олборлолт явуулж, 1200,0 мян м<sup>3</sup> хөрс хуулж, 170.0 мян тн хүдэр олборлож, өмнөх оны үлдэгдэл хүдэр 30.0 мян тн, нийт 200.0 мян тн хүдэр боловсруулж, 65-75%-ийн дундаж агуулгатай 48000 тн жонш, 35% агуулгатай хүдэр 70000 тн гаргаж ОХУ болон БНХАУ-д борлуулахаар тусгасан.

Тус компани 2023 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийт 537,5 мян м<sup>3</sup> хөрс хуулж, 98, 0 мян тн хүдэр олборлож, 20 мян тн жонш гаргаад байна.

### 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайгаас хүдэр олборлох, ачиж тээвэрлэх үед тоос босож хөрс, ургамал, орчныг дарах, ажиллагсад, ойр байгаа нутгийн иргэдийн амьсгалах агаар бохирдох тул тоосжилтын нөлөөллийг бууруулах зорилгоор 2023 онд дараах арга хэмжээг авсан:

1. ЧЦД уурхайгаас Мааньт дахь борлуулалтын хэсэг хүртэлх 48 км хайрган хучилттай замыг дахин засварласан. Зам засварын ажлыг 7-р сарын 25-наас 9-р сарын 20-ны хооронд гүйцэтгэсэн бөгөөд энэ хугацаанд Зам гүүр барих тусгай зөвшөөрөл бүхий “Толын жим” ХХК-иар ажлыг гүйцэтгүүлсэн. 48км урттай , 8м өргөнтэй, 0.6м зузаан замд нөхөөс засвар хийхэд 15000 м<sup>3</sup> хайрга, шороог уурхайн талбайгаас зөөж асгаж, түрж тэгшилж индүүдсэн. Мөн 8 м урттай, 240 мм-ийн диаметртэй, 8 ширхэг трубаг замын трасс дагуу таарах 4 ш жалга, ус урсах газруудад ус зайлуулах шугам тавьсан.

2. Мөн уурхайн болон баяжуулах үйлдвэрийн технологийн замуудыг хайрган хучилттай болгон стандартын дагуу 29 км зам тавьсан. Дээрх зам засварын ажилуудад тус компани 2023 онд нийт **430 сая** төгрөгийг зарцуулсан болно.

3. Уурхайн орчимд тоосжилтийг дарах зорилгоор гол замуудыг усалж байсан. Усны төлбөрт 4,08 сая төгрөг төлсөн.

4. Баяжуулах үйлдвэрийн эргэн тойрон талбайг бетондсоноор хөрс бохирдуулахаас сэргийлсэн. /эдгээр зардлыг уурхайн ашиглалтын зардалд тооцсон/

Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнд 2023 онд **594,08 сая төгрөг** зарцуулсан.

## 2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Чулуут цагаан дэлийн уурхай 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд: Дотоод овоолгоор 2-р биетийн өмнө хэсэгт 1,5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ба 2023 онд хуулах хөрснөөс 250 мян.м3 хөрсийг дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж, өмнө жилийн техникийн нөхөн сэргээлт хийсэн 1,5 га талбайд хар шороон хөрс буулгаж, түрж тэгшилж, мэргэжлийн байгууллагаар ерхөг, царгас, согоовор зэрэг бэлчээрийн ургамлын үр суулгуулж стандартын дагуу биологийн нөхөн сэргээлт хийлгэхээр тусгасан.

2023 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд 5000ш Улиас, Хайлаас, Шар хуайс зэрэг мод, Баян суман дахь Борлуулах хэсгийн талбайд 100ш Улиас мод тарихаар тусгасан. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд 45,2 сая төгрөг зарцуулна.

Орчны хяналт шинжилгээ: уурхайн хөрсний тогтсон 2 цэгээс 1,1 ш дээжийг улирал бүр, унд ахуйд ашиглаж буй худгаас улирал бүр усны 1 дээж авч Геологийн төв лабораториболон ШУА-ийн Геоэкологи, Газарзүйн хүрээлэнд шинжилгээ хийлгэхээр тусгасан.

ЧЦД-ийн уурхайгаас Мааньт хүртэл өөрсдийн тавьсан 48 км бүтээгдэхүүн тээврийн хайрган хучилттай замыг усалж арчилахаар тус тус тусгасан ба 2023 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд **нийт 400,0 сая төг/хяналтын хуудсаар 6,5 сая төг/** зарцуулахаар тусгасан. /Техникийн болон биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт, бусад холбогдох зардлууд уурхайн олборлолтын зардалд суусан/

**Гүйцэтгэл:** 2023 онд хүдрийн 2-р биетийн өмнө жилүүдэд ашигласан 1,5 га талбайд 250 мян м3 хөрс дүүргэж тэгшлэн, техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Мөн 1,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, шимт хөрсөөр хучиж царгас, ерхөг, согоовор зэрэг бэлчээрийн олон наст ургамлын үр тарьсан.

2023 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан ”Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд Гавьяат Агрономич Б.Чимэд зөвлөж Мод үржүүлгийн газар байгуулсан. 2023 онд 1 -1,5 м өндөртэй 1000ш Улиас, Улиасны харандаа

1000ш, Бүйлс 200ш-г тус тус тарьсан ба, Хайлаасны 2 кг үр суулгаснаас 50%-ийн ургалттай буюу ойролцоогоор 80 мянган үрсэлгээ суулгац ургасан. Мөн Баян суманд 1 – 1,5м өндөртэй 500ш Хайлаас мод тарьсан.

Орчны хяналт шинжилгээ: Уурхайд 2023 оны 6-р сард Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөс судалгаа шинжилгээний баг 22 хүний бүрэлдэхүүнтэй очиж судалгаа шинжилгээ хийсэн ба хөрсний 15 цэг тогтоож дээж авч, усны 2 худгаас дээж авч, нийт 17 ш дээжийг ШУА-н Газар зүй, Гео экологийн хүрээлэнд шинжилгээ хийлгэсэн.

ЧЦД уурхайгаас Мааньт дахь борлуулалтын хэсэг хүртэлх 48 км хайрган хучилттай замыг дахин засварлаж, уурхайн болон баяжуулах үйлдвэрийн технологийн замуудыг хайрган хучилттай болгож 29 км зам тавьсан.

2023 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт **1019,78** сая төг зарцуулсан.

#### **Техникийн нөхөн сэргээлт:**

Хүдрийн 2-р хүдрийн биетийн өмнө хэсэгт өмнө жилүүдэд ашигласан 1,5 га талбайд 250 мян м<sup>3</sup> хөрс дүүргэж тэгшилж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. Талбайд уурхайн 2023 онд хуулсан 100 мян м<sup>3</sup> хөрс, хажуу талд байсан 3 овоолгуудыг түрж, хийж тэгшилсэн. /эдгээр ажлын зардал **140 сая** төг уурхайн олборлолтын зардалд суусан/

#### **Биологийн нөхөн сэргээлт:**

2-р биетийн 1,5 га талбайг хар шороон хөрсөөр хучиж, 0,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, ерхөг, царгас, согооворын үр суулгасан. Биологийн нөхөн сэргээлтэд **13 сая төгрөгийн** зардал гаргасан.

### **3. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт**

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд: 2023 онд тус компани Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд уурхайн тусгай зөвшөөрлийнхөө талбайд Гавьяат Агрономич Б.Чимэд зөвлөж Мод үржүүлгийн газар байгуулсан. 2023 онд 1 -1,5 м өндөртэй 1000ш Улиас, Улиасны харандаа 1000ш, Бүйлс 200ш-г тус тус тарьсан ба,

Хайлаасны 2 кг үр суулгаснаас 50%-ийн ургалттай буюу ойролцоогоор 80 мянган үрсэлгээ суулгац ургасан. Мөн Баян суманд 1 – 1,5м өндөртэй 500ш Хайлаас мод тарьсан.

Баянцагаан сумын 2-р багийн 20 айлын өвөлжөө бууц түрж, багийн төвийн байрны хашааг барьж, багт мал угаах ванн байгуулсан. Сум багт нийт 100 гаруй сая төгрөгийн зардал зарцуулсан.

2023 дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд нийт **145 сая** төгрөг зарцуулсан.

#### 4. Хог хаягдлын менежментын тайлан

Уурхайн хатуу хаягдал болох хоосон чулуулгийг өмнө жилүүдэд олборлосон хоосон талбайд хийж, дүүргэж тэгшилж, техникийн нөхөн сэргээлтэнд ашигласан. Ахуйн хог хаягдлыг хогийн цэгт цуглуулж, ангилан ялгаж, цэвэрлэн шатааж, ариутгасан. Баяжуулах үйлдвэр шинээр барьж ашиглалтанд оруулсан. 120 ажилчин амьдрах 30 өрөөтэй, өрөө бүртээ дотор жорлон душтэй кемп, 120 хүний хооллох зориулалттай 2 гал тогоо, оффис ажилчдын байр барьж ашиглалтанд оруулсан бөгөөд 00, цэвэр бохирын асуудлыг шийдсэн, тусгай ёткомть суурилуулсан /эдгээр зардлыг уурхайн ашиглалтын зардалд тооцсон/ ба дүүрэх үед соруулан, сумын зөвшөөрөгдсөн цэгт хаяна.

“Түмэн эгшиг” ХХК-тай Аюултай хог хаягдал зайлуулах гэрээ байгуулсан. Хог хаягдлын төлбөрт орон нутагт 1,6 сая төгрөг төлсөн.

#### 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ЧЦД уурхайд 2023 оны 6-р сард БОАЖЯ-с Байгаль орчны судалгаа шинжилгээний төвөөс судалгаа шинжилгээний баг 22 хүний бүрэлдэхүүнтэй очиж судалгаа шинжилгээ явуулсан бөгөөд хөрсний 15 цэг тогтоож дээж авч, усны 2 худгаас дээж авч, нийт 17 ш дээжийг ШУА-н Газар зүй, Гео экологийн хүрээлэнд шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээнд 2,7 сая төгрөг зарцуулсан. Ашиглах 3 ш худагт тоолуур тавьж, баталгаажуулсан. Орчны хяналт шинжилгээнд 2023 онд **5,1 сая төгрөг** зарцуулсан.

## 6. Удирдлага зохион байгуулалт

ХАБЭА, БО-н орон тооны мэргэжилтэн авч ажиллуулж, ХАБЭА-н зөвлөн туслах үйлчилгээ авч, БОТ, ХАБЭАТ, ГАБТ, ДХТ хууль журмуудын талаар 2 удаа сургалт явуулсан. Уурхайд орон тооны мэргэжлийн эмч ажиллуулж, ажилчдыг байнгын хэрэгцээт эм тариа, аптекаар үнэгүй хангаж, эмчилгээ хийх болсон.

Сум баг орон нутагт Хандив 100 гаруй сая төг өгсөн бөгөөд 2023 онд Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд **121** сая төг зарцуулсан.

## 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах

Олборлолтын болон нөхөн сэргээлтийн ажлын тайланг орон нутгийн /сумын/ захиргаанд 9-р сард тайлагнасан. Багийн 3,9 сарын хуралд танилцуулсан.

**Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардлын тайлан:** 2023 онд ЧЦД уурхайн Менежментийн төлөвлөгөөнд байгаль орчин хамгаалах нөхөн сэргээлтийн ажилд 400,0 сая төг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2023 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн зардалд нийт **1019,78** сая төг зарцуулсан.

Үүнээс:

1. Сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнд **594,08 сая төгрөг**, үүнээс Зам засварт **430,0 сая төгрөг**,
2. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд **13,0 сая төгрөг**, техникийн н/с **140 сая төг**
3. Тэрбум мод хөтөлбөр мод тарихад **45,0 сая төгрөг**
4. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтэд **100 сая төгрөг**,
5. Хог хаягдлын зардалд **1,6 сая төгрөг**,
6. Орчны хяналт шинжилгээнд **5,1 сая төгрөг**.
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтад **121,0 сая төгрөг**

